

ХОТ, ТОСГОНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ

1993 оны 12 дугаар сарын 20-ны өдөр

Хуулийн нэр	Хуулийн зорилго	Худалдаатай холбоотой заалтууд
ХОТ, ТОСГОНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ 1993 оны 12 дугаар сарын 20-ны өдөр	Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгон, тэдгээрийн нийгэм, эдийн засгийн үндэс, удирдлагын үйл ажиллагааны зарчим, тогтолцоо, бүрэн эрхийг тодорхойлж, хот, тосгоны удирдлагаас засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага болон аж ахуйн нэгж, байгууллага, оршин суугчидтай харилцах харилцааг зохицуулахад оршино.	20 дугаар зүйл. Орон сууц нийтийн аж ахуй ба худалдаа үйлчилгээний талаархи хот, тосгоны захирагчийн бүрэн эрх 1.Хот, тосгоны өөрийн мэдлийн орон сууцыг тогтоосон журмын дагуу хуваарилна. 2.Хот, тосгоны тохижилтын ажилд аж ахуйн нэгж, байгууллагыг гэрээний үндсэн дээр, түүнчлэн оршин суугчдыг зохион байгуулж оролцуулна. 3.Хот, тосгоны өөрийн мэдлийн аж ахуй, худалдаа, үйлчилгээний байгууллагын ажиллах цагийн хуваарийг тогтооно. 4.Худалдаа, үйлчилгээний газарт эрүүл ахуйн шаардлагыг хангуулна. 5.Худалдаа, яармаг болон үйлчилгээний бусад арга хэмжээг зохион байгуулна.